

“УЛААНБААТАР ЛИФТ” НӨҮГ-ЫН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН
ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 30

Улаанбаатар хот

“Улаанбаатар лифт” НӨҮГ-т хандаж иргэд, ААНБ, СӨХ-оос 2024 оны байдлаар нийт 30 өргөдөл ирсэн байна. Үүнээс 22 гомдол, 8 хүсэлт ирснийг 100% шийдвэрлэсэн байна. Хугацаа хэтэрч хаагдсан болон шийдвэрлээгүй, судалж буй өргөдөл байхгүй. Өргөдөл, гомдлыг цаг хугацаанд нь бүрэн шийдвэрлэж ажиллахын тулд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Өргөдөл, гомдлын нэгдсэн систем <http3://erp.ulaanbaatar.mn> програмын ашиглалт, хэрэглээний талаар байгууллагын хэмжээнд өргөдөл, гомдлыг шийдвэрлэх түвшний албан хаагчдад шийдвэрлэлтийг анхаарч ажиллахыг үүрэгжүүлсэн.
- Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг 9 хоногт багтаан шийдвэрлэхээр зорьж ажилласан ба зорилтдоо хүрч ажиллаж байна.

Хандалтын байдлаар гүүрэн гарцтай холбоотой 5 гомдол, орон сууцны лифтний үйл ажиллагаатай холбоотой нийт 17 өргөдөл, гомдол хүлээн авч цаг хугацаандаа шийдвэрлэхэд нь хяналт тавин ажилласан.

Өргөдөл гаргасан иргэн, ААНБ, СӨХ-той газар дээр нь очиж биечлэн уулзах, утсаар холбогдон хариу өгөх зэргээр түргэн шуурхай хугацаанд иргэний талд өргөдөл, гомдлыг шийдвэрлэн ажиллаж байна.

- Тайлант хугацаанд иргэдээс уулзалт хийх санал ирээгүй болно.
- Өргөдөл гомдлыг шийдвэрлэх тутамдаа газрын даргад танилцуулж хэвшсэн.
- Тайлан мэдээнд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн, мөн шийдвэрлэлтийн явцад удаа дараа зөрчил гаргасан албан хаагч байхгүй.

Цаашид манай байгууллагад хандаж иргэд болон ААНБ, СӨХ-ноос ирсэн өргөдөл гомдлыг цаг тухайд нь шийдвэрлэхийг зорьж байна.

ХЯНАСАН:
ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:
АРХИВ, БИЧИГ ХЭРЭГ, ДОТООД
АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Д.ГАН-ЭРДЭНЭ

Номин

Э.НОМИН-ЭРДЭНЭ

“УЛААНБААТАР ЛИФТ” НӨҮГ
ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН, МЭДЭЭ

Хамрах хугацаа: 2024/01/02-2024/12/30

2024 оны 12 дугаар сарын 30

Улаанбаатар хот

Д/д	Хаанаас (Хэнээс) ирүүлсэн	Хүлээн авсан он, сар, өдөр	Агуулга	Шилжүүлсэн газар, алба, ажилтан	Хэрхэн шийдвэрлэсэн	Хариу өгсөн хэлбэр (он, сар, өдөр, амаар болон бичгээр)	Тайлбар
1	2	3	4	5	6	7	8
1	Гомдол (иргэн Т.С, 99041697)	2024.02.02	ХУД-ийн 120 мянгатын арын зам дагуу нээгдсэн гүүрэн гарц өглөө ачааллын үед ажиллахгүй байгаад гомдолтой байна. Өдөр ажиллаад өглөө хаачихаад байна. Холбогдох байгууллагад нь уламжилж өгнө үү.	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат	Тус иргэний хүсэлтийг хүлээн авч холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Лифтчингүүдэд цагийн хуваарийн дагуу ажиллах үүрэг даалгавар өгч өдөр тутам хяналт тавьж ажиллахыг хяналтын инженер Б.Батзориг, механик инженер Б.Батбаатар нарт үүрэг болгож хяналт тавин ажиллаж байна.	2024.02.22 утсаар мэдээлэл өгсөн.	
2	Хүсэлт (иргэн Ө.Б, 94002112)	2024.02.05	Хотын стандарт, хяналтын газарт: БГД 34-р хорооны 6-р бичил хорооны 5А байр 3-р орцын оршин суугч оросын лифт сольсон боловч утсарсан кампани нь Улаанбаатар лифтийн газар хүлээж авна гэхдээ цагаан сарын дараа авна гэнэ, сөх-д хандсан боловч одоохон завгүй тул цагаан сарын дараа хүлээн авна гээд комисс бас цагаан сарын дараа л авна гээд дийлэхгүй болоод гомдол гаргаж байна.	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат	Угсралтын ажил бүрэн дуусаж бүрэн магадлал хийгдсэн, Улсын комисс ажиллахаар хүлээгдэж байна. Утсаар холбогдож гомдол гаргасан иргэнд тайлбар өгсөн.	2024.02.08 утсаар мэдээлэл өгсөн.	

3	Гомдол (иргэн Н.Санлах, 99140370)	2024.02.07	БГД-ийн 6 дугаар хороо 107 байрны лифт ажиллахгүй 6 сар болж байна. Удаа дараа гомдол гаргаж байгаа ба "Нийслэл, Дүүргийн төсвийн төсөл арга хэмжээний саналд санал оруулахаар шийдвэрлэлээ." гэсэн ба БГД-ийн төсөвт тусгагдсан гэх ч шийдвэрлэхгүй байна. Гомдолтой байна, уламжилж өгнө үү	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат	Иргэн Н.Санлахтай холбогдож мэдээлэл өгөв. Голден парк хотхоны 107 дугаар байрны цахилгаан шатыг Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинэчилж байгаа бөгөөд худалдан авах ажиллагааг Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газар зохион байгуулж байгаа болно.	2024.02.08 утсаар мэдээлэл өгсөн.
4	Гомдол (иргэн Я.Энхмаа, 85897707)	2024.02.07	БЗД-ийн "Голден парк" 103 дугаар байрны цахилгаан шат ажиллахгүй 2 сар болж байна. 16 давхар байр шүү дээ. Үнэхээр хүндрэлтэй байна, уламжилж яаралтай арга хэмжээ авч өгнө үү	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат	Иргэн Я.Энхмаатай холбогдож өнөөгийн нөхцөл байдлыг танилцуулсан. Тус байрны лифт нь Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинэчлэгдэж байгаа. бөгөөд Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газар тус шинэчлэлийн ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулж байгаа болно.	2024.02.08 утсаар мэдээлэл өгсөн.
5	Гомдол (иргэн Н.Төмөрхүү, 99234291)	2024.02.09	СХД-ийн 14 дүгээр хорооны 17-30 тоотын оршин суугч байна. Цахилгаан шат нь ажиллахгүй 4 хонож байна. Холбогдох байгууллагад хандсан ч өнөөдрийг хүртэл шийдэгдэхгүй байгаад байна. Миний гомдлыг холбогдох байгууллагад уламжилж өгнө үү.	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат	СХД-ийн 14 дүгээр хорооны 17 дугаар байрны цахилгаан шатыг 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдөр засварлаж хэвийн ажиллагаанд оруулав.	2024.02.15 утсаар мэдээлэл өгсөн.
6	Гомдол (иргэн Т.Энхтуул, 89112254)	2024.02.23	БГД-ийн 34 дүгээр хорооны 5а байрны 3 дугаар орцны оршин суугч байна. 2 сарын өмнө лифт сольсон бөгөөд гүйцэтгэгч компани нь лифтээ хийгээд дууссан ч хариуцсан төрийн байгууллага хүлээж авахгүй байгаа учраас ашиглалтад орохгүй байна. Тиймээс лифтийг маш яаралтай шалгаж хүлээж авч ашиглалтад оруулж өгнө үү.	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат	2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 11 цагт Улсын комисс ажиллах хуваарь батлагдсан.	2024.03.04 утсаар мэдээлэл өгсөн.

7	Гомдол (иргэн Ц.Байгалмаа, 88074148)	2024.02.23	БГД-ийн 34 дүгээр хорооны 5а байрны 3 дугаар орцны оршин суугч байна. 2 сарын өмнө лифт сольсон бөгөөд гүйцэтгэгч компани нь лифтээ хийгээд дууссан ч хариуцсан төрийн байгууллага хүлээж авахгүй байгаа учраас ашиглалтад орохгүй байна. Тиймээс лифтийг маш яаралтай шалгаж хүлээж авч ашиглалтад оруулж өгнө үү.	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат	2024 оны 03 дугаар сарын 07-ны өдөр 11 цагт Улсын комисс ажиллах хуваарь батлагдсан.	2024.03.04 утсаар мэдээлэл өгсөн.	
8	Гомдол (иргэн Л.Мөнхсайхан, 88082461)	2024.03.06	СХД-ийн 13 дугаар хорооны 8 дугаар байрны 5 дугаар орцны цахилгаан шатыг нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийж байгаа юм. Гэтэл тухайн байгууллагын хийсэн лифт чанарын шаардлага хангахгүй байна. Тиймээс шалгаж хүлээж авдаг газар нь дахин засварлуулж байж хүлээж авахыг шаардаж байна. Хүний амь настай холбоотой хэрэгслийг чанаргүй хийж болохгүй шүү дээ. Холбогдох газарт нь уламжилж хариу өгнө үү.	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат	Барилга хот байгуулалтын яамны Салбарын Улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 02-00/01 дугаартай "Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай" удирдамж, гүйцэтгэгч "Фүшили элеватор" ХХК-ийн бүрэн магадлал хийлгэх тухай хүсэлтийг үндэслэн Стандарт хэмжил зүйн газрын дэргэдэх Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн Өргөх байгууламжийн шинжээч мэргэжилтэн Д.Амгаланбаатар, Барилгын техникийн хяналтын улсын байцаагч Б.Гансүх нар ЛТААД-ийн дагуу угсралт, техникийн бэлэн байдалд үзлэг, бүрэн магадлалыг хийж 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн техникийн магадлалын акт үйлдсэн байна. Бүрэн магадлалын актыг үндэслэн Хотын стандарт, хяналтын газарт Улсын комисс ажиллуулах хүсэлтийг хүргүүлсэн.	2024.03.13 утсаар мэдээлэл өгсөн.	

9	Гомдол (иргэн Ц.Ариунгэрэл, 89004044)	2024.03.20	100 айлын гүүрэн гарцны урд талын лифт ажиллахгүй байна, товчийг нь муухай скочоор наасан өнгө үзэмжгүй байна, цэвэрлэгээ үйлчилгээ байхгүй байна. Холбогдох газарт нь уламжилж өгнө үү.	Инженер техникийн хэсэг, хяналтын инженер Б.Батзориг	2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр 100 айлын гүүрэн гарцны урд талын лифтийн хагархай байсан шилийг сольж, хаалганы инверторыг сольж хэвийн ажиллагаанд оруулсан.	2024.03.25 утсаар мэдээлэл өгсөн.
10	Хүсэлт (иргэн Б.Ганболд, 80070150)	2024.03.21	Нийслэлийн Засаг бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар танаа: Өргөдөл гаргах нь /Хавсралт 3 хуудас/ (Агуулга: Орон сууцны цахилгаан шатыг шинэчлэх хүсэлт)	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат	СХД-ийн 29 дүгээр хороо, Кремль СӨХ-ны 131/2 дугаар байрны 2 дугаар орцны хүн зөөврийн цахилгаан шат 2024 онд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр шинэчлэгдэх цахилгаан шатуудын жагсаалтад хамрагдсан болно.	2024.04.01 утсаар мэдээлэл өгсөн.
11	Гомдол (иргэн С.Сэргэлэн, 94008686)	2024.04.02	БЗД-ийн 15-р хорооны 5-р байрны 3-р орцны иргэн байна. Манай орцны лифт өнгөрсөн жил шинээр хийснээс хойш 7 хоног 2-3 удаа эвдрээд бараг ажиллахгүй гэж хэлэхэд болохоор байна. СӨХ-ндөө хэлэхэд Улаанбаатар лифт гэдэг компаниас хариуцуулж өгсөн гэдэг. Энэ компаниас асуухад хийсэн компани нь програм дутуу уншуулсан гэж хэлээд өөр арга хэмжээ авсангүй. Тендерээр ажил хийсэн газартаа шаардлага тавьж бүрэн дууссан ажил хүлээж авах хэрэгтэй шүү дээ. Би маш хүнд өвчтэй хүүхэдтэй байнга цахилгаан шат хэрэглэх шаардлагатай байдаг. Энэ асуудлыг маш яаралтай нэг мер шийдэж хариу өгнө үү.	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат	Гүйцэтгэгч "Оакс экспресс монголиа" ХХК-ийн угсралтын инженер Б.Өлзийбаяр 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 18 цаг 20 минутад очиж хаалганы тохиргоо хийж хэвийн ажиллагаанд оруулсан. СӨХ-ны дарга болон гомдол гаргагчид хэвийн болсон талаар мэдэгдсэн. Одоо хэвийн ажиллаж байна.	2024.04.04 утсаар мэдээлэл өгсөн.
12	Гомдол (иргэн Л.Гомбосүрэн, 801110199)	2024.05.06	13-р хорооллын байрны 10-р байрны 5-р орцны цахилгаан шат байнга гацаж, эвдэрч байна. Жоохон хүүхдүүд байнга гацаж, уйлж байна. БНХАУ-ын ногоон цахилгаан шат тавиад 6-7 жил болж байгаа юм байна. СӨХ-д хэлэхээр хугацаа нь болоогүй гэдэг. Энэ цахилгаан шатыг энэ жилдээ Солонгос сайн цахилгаан шатаар заавал солиулмаар байна. Холбогдох газарт нь уламжилж өгнө үү.	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат	Иргэн Л.Гомбосүрэнгийн мэдээллийн дагуу холбогдож тус лифтийн талаарх санал хүсэлтийг сонсож ашиглагч "Сэлбэ" СӨХ-ны гүйцэтгэх захирал Өлзийбаяр, техник үйлчилгээг хариуцдаг "Цамхаг" ХХК-ийн инженер Амарра нарт иргэд, суугчдын саналыг өдөр тутмын ажилдаа тусган аюулгүй	2024.05.07 утсаар мэдээлэл өгсөн.

13	Хүсэлт (иргэн Г.Түмэнцэцэг, 91900989)	2024.05.10	БЗД-ийн 25-р хороо, 37-р байрны цахилгаан шатны хугацаа нь 2015 онд дууссан. Цахилгаан шатаар явж байхад гацах, эвдрэх асуудал байнга гарч байна. Холбогдох газарт нь уламжилж арга хэмжээ авч өгнө үү.	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2024 онд шинэчлэгдэх 35 лифтийн жагсаалтад хамрагдсан. Тендер шалгаруулалтыг НЗДТГ зохион байгуулж байгаа. Хүсэлт гаргасан иргэн Г.Түмэнцэцэгтэй утсаар холбогдож мэдээллэл өгөв.	2024.05.13 утсаар мэдээлэл өгсөн.	зорчих, амьдрах нөхцөлийг хангаж ажиллах талаар зөвлөгөө өгч ажиллаа.	
14	Гомдол (иргэн Н.Лхагвасүрэн, 99187760)	2024.05.13	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар танаа: БГД-ийн 34 дүгээр хороо 21 дүгээр байрны 2 дугаар орцны цахилгаан шат ажиллахгүй байна. Уг асуудлаар удаа дараа холбогдох байгууллагад нь ханддаг боловч ямар ч арга хэмжээ авахгүй өнөөдрийг хүрч байна. Өндөр настай болон бага насны хүүхэдтэй хүмүүст хүндрэлтэй байна шүү дээ. Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын Орон сууц, нийтийн аж ахуй үйлчилгээ, сууц өмчлөгчдийн холбоо хариуцсан мэргэжилтэн М.Мөнх-Өлзий Иргэн н.Лхагвасүрэнгийн гомдлын дагуу Улаанбаатар лифт НӨҮГ-ын Ерөнхий инженер н.Энхбаттай 99080232 холбогдож яаралтай арга хэмжээ авч хэвийн болгож ажиллах талаар үүрэг өгч ажиллалаа гэсэн боловч одоо хүртэл шийдэгдээгүй хөгшин настай хүмүүс маш хэцүү нөхцөлд амьдарч байна. Энэ асуудлыг яаралтай шийдэж хариу өгнө үү.	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат	БГД-ийн 34 дүгээр хороо, 21 дүгээр байрны 2 дугаар орцны цахилгаан шат Нийслэлийн төсвийн хөрөнгөөр шинэчлэгдэж байна. ажлыг Оакс экспресс ХХК гүйцэтгэж байна.	2024.05.16 утсаар мэдээлэл өгсөн.		
15	Гомдол (иргэн)	2024.05.14	ХУД-ийн 19 дүгээр хорооны 54Д байрны Жи-108 СӨХ-оос холбогдож байна. 35 лифтийн хөрөнгө мөнгө улсын төсөвт төсөвлөгдөөд 5 сар болж байгаа юм. Нэг ширхэг лифтийг нь манай байранд тавихаар болсон юм. Уг асуудал маш удаан хүлээгдэж байгаад	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер	Иргэн Г.Саранчимэгтэй утсаар холбогдож 2024 онд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр шинэчлэгдэж байгаа лифтийн шинэчлэлийн ажлын явцын болон тендер шалгаруулалтын үр дүнгийн	2024.05.15 утсаар мэдээлэл өгсөн.		

16	Г.Саранчимэг, 99774046)		гомдол гаргаж байна. Улаанбаатар лиффтнээс асуухаар танайх бол орсон нийслэлийн худалдан авах ажиллагааны газраасаа л асуу гэх юм. Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас асуухаар мэдэхгүй, одоогоор зарлагдсан юм байхгүй гэх юм. Холбогдох байгууллагад нь уламжлан яаралтай шийдвэрлэж өгнө үү.	М.Энхбат	хуулийн хугацаа хүлээгдэж байгаа талаар мэдээлэл өгөв.	
	Хүсэлт (иргэн Л.Ангараг, 99061652)	2024.05.15	Миний бие Лхамжав овогтой Ангараг ДЦС-II ТӨХК-д ажиллаж байгаад 2023 оны 02-р сарын 1-нээс өндөр насны тэтгэвэрт гарсан. Одоо "Улаанбаатар лифт" НӨҮГ-т хяналтын инженерээр ажиллаж байна. Тус газар ажиллаж байх хугацаандаа нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй байх хүсэлтэй байгаа тул хүсэлтийг минь хүлээн авна уу.	Газрын Дарга Д.Ган- Эрдэнэ	Л.Ангарагийн Нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй байх хүсэлтийг хүлээн авч хүсэлтийн дагуу шийдвэрлэлээ.	2024.05.30 Иргэнтэй биеэр уулзаж хариу хүргүүлсэн.
17	Хүсэлт (иргэн М.Энхбат, 99080232)	2024.05.15	Мяхбал овогтой Энхбат миний бие өндөр насны тэтгэвэрт гарах болсон тул 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгож ажлаас чөлөөлж өгнө үү.	Газрын Дарга Д.Ган-Эрдэнэ	М.Энхбатын хүсэлтийн дагуу 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн Б/09 дүгээр тушаалаар шийдвэрлэв.	2024.05.30 Иргэнтэй биеэр уулзаж хариу хүргүүлсэн.
18	Хүсэлт (иргэн Д.Санжням, 88055049)	2024.07.01	Даш-Очир овогтой Санжням миний бие тус байгууллагад 2023 оны 06 дугаар сараас ахлах нягтлан бодогчоор ажилласан. Өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх хүсэлтэй байгаа тул ажлаас чөлөөлж өгнө үү.	Газрын Дарга Д.Ган-Эрдэнэ	Д.Санжнямын хүсэлтийн дагуу 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн Б/29 дүгээр тушаалаар шийдвэрлэв.	2024.07.05 Иргэнтэй биеэр уулзаж хариу хүргүүлсэн.
19	Гомдол (иргэн Х.Баттулга, 99967003)	2024.07.09	Улаанбаатар лифт ОНӨТҮГ-т: БЗД-ийн 15 дугаар хороо, 13-р хороолол, 6-р байрны 2-р орцны оршин суугч байна. Манай цахилгаан шат 7 хоногт 1-5 удаа гацдаг. 1-р давхраас дуудахад 1-3 давхрын хооронд явж гацдаг. Дээд давхарт ирээд хаалга нь онгойхоо больчихно. Манайх 9 давхар байр. Хамгийн гол нь засварын асуудлыг Оргил дэнж СӨХ	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат	Иргэн Х.Баттулгын гомдлын мөрөөр 13-о хороолол, 6-р байрны 2-р орцны лифтийн хэвийн ажиллагааг хяналтын инженер Б.Байгалийн хамт давхар бүрд зогсоож шалгав. Шалгах явцад лиффтэнд ямар нэгэн техникийн доголдол гараагүй хэвийн	2024.07.16 утсаар мэдээлэл өгсөн

20	Гомдол (иргэн О.Цэвэлмаа, 98200203)	2024.07.16	хариуцдаг боловч цахилгаан шат мэддэг хүн байдаггүй. Мөн манай байрны урд талд Улаанбаатар лифт ХХК байдаг. Загасчны морь усгүй гэдэг шиг дэргэд нь байхад янзалж өгдөггүй. СӨХ олон удаа хүсэлт гаргаж байсан. 70-с дээш насны өндөр настнууд явах боломжгүй байна. Гомдолтой байна.	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат	ажиллаж байв, Энэ тухай иргэн Б.Батулгад утсаар мэдэгдэж цаашид лифтийн хэвийн ажиллагааны талаар харилцан мэдээлэлтэй байж анхаарч ажиллахаар санал солилцов.	2024.07.19 утсаар мэдээлэл өгсөн
21	Хүсэлт (иргэн Н.Төмөрхүү, 99234291)	2024.07.29	СХД-ийн 37-р хороо Содон хорооллын оршин суугч байна. Манайх 15 давхарт амьдардаг айл. Манай байрны цахилгаан шат нь байр байн унаад байдаг. Өчигдөр манай хүүхэд цахилгаан шатанд суугаад нэг давхраас суутал В1 рүү шууд унасан байна, миний хүүхэд маш их айчихсан орж ирсэн. СӨХ энэ энэ асуудалд арга хэмжээ авахгүй байна. Энэ асуудалд холбогдох байгууллагаас нь шалгаж, хариу өгнө үү.	Инженер техникийн хэсэг, ерөнхий инженер М.Энхбат	Сонгинохайрхан дүүргийн 37 дугаар хороо, Содон хорооллын 115 дугаар байрны 2 дугаар орцын оршин суугч О.Цэвэлмаагийн гомдлын мөрөөр судалж Содон СӨХ-ийн дарга Бичинлхамтай холбогдож ЛТААД-ийн шаардлагад нийцүүлэн сар бүрийн техник үйлчилгээний чанарыг сайжруулж оршин суугчдын аюулгүй, ая тухтай амьдрах нөхцөлийг хангаж ажиллах талаар санал солилцож зөвлөгөө өгөв.	2024.07.30 утсаар мэдээлэл өгсөн
22	Гомдол (иргэн Ж.Цэвээндорж, 91994100)	2024.08.23	СХД-ийн 14 дүгээр хорооны 17-30 тоотын оршин суугч байна. Цахилгаан шат нь ажиллахгүй сар гаран хонож байна. Холбогдох байгууллагад хандсан ч өнөөдрийг хүртэл шийдэгдэхгүй байгаа байна. Миний гомдлыг холбогдох байгууллагад уламжилж өгнө үү.	Инженер техникийн хэсэг, хяналтын инженер Б.Байгаль	Тус иргэний өгсөн гомдлын дагуу ХУД-ийн 2-р хорооны нутаг дэвсгэрт байрлах 19-ийн гүүрэн гарцын лифтуудийг шалгаж үзэхэд хэвийн ажиллагаатай байв. 8 дугаар сард нийт эвдрэл гэмтлийн 5 дуудлага ирсэн бөгөөд цаг тухай бүрд нь засварлаж	2024.08.30 утсаар мэдээлэл өгсөн

					лифтийг хэвийн ажиллагаанд оруулсан байна.	
23	Гомдол (иргэн Д.Гантөмөр, 89047620)	2024.08.27	байх. Холбогдох харьяа байгууллагад нь уламжлан өгнө үү. БГД-ийн 34 дүгээр хороо, 21-р байрны цахилгаан шат 1-р сараас хойш ажиллахгүй байгаа. 7-р сард шинэ цахилгаан шат тавьсан боловч комисс хүлээж авахгүй байгаа гээд одоог хүртэл цахилгаан шатгүй байна. Арга хэмжээ авч өгнө үү.	Инженер техникийн хэсэг, хяналтын инженер Б.Байгаль	Манай байгууллагаас 2024 оны 08 дугаар сарын 14-ний өдөр улсын комисс ажиллуулах тухай хүсэлтийг 140 тоот албан бичгээр "Хяналт шалгалтын газар"-т хүргүүлсэн. Тус газраас тодруулахад 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр улсын комисс ажиллах хуваарь батлагдсан байна.	2024.08.30 утсаар мэдээлэл өгсөн
24	Гомдол (иргэн О.Нандинцэцэг, 80020204)	2024.09.27	100 айлын гүүрэн гарцын урд талын цахилгаан шат нь ажиллахгүй удаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгшин настай хүмүүст шатаар гарахад хэцүү байна. Уламжилж өгнө үү.	Инженер техникийн хэсэг, хяналтын инженер Ц.Уранбилэг	СБД-ийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 100 айлын гүүрэн гарцын урд талын цахилгаан шатны хонгилын шил хагарч цахилгаан шат түр хугацаагаар зогссон байсныг 2024 оны 10 дугаар сарын 01-ний засварлан хэвийн ажиллагаанд оруулав.	2024.10.01 утсаар мэдээлэл өгсөн
25	Гомдол (иргэн Г.Энхтөр, 94109955)	2024.09.27	Улаанбаатар лифт нийслэлийн өмчит газар гомдол гаргасаар байна. ХУД-ийн 19-р хороо 54-д байрны лифт нь 2,3 жилийн өмнөөс лифт ажиллагаагүй болоод улсаас засахаар болоод 8 сард сэлбэг нь ирсэн. 2 сар засаад одоог болтол дуусаагүй байна. Уг асуудлыг яаралтай шийдвэрлэж засварын ажлыг дуусгаж өгнө үү.	Инженер техникийн хэсэг, хяналтын инженер Ц.Уранбилэг	Цахилгаан шат угсралтын ажилд манай байгууллага хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд цахилгаан шатны заслын ажлыг хуваарийн дагуу 10 дугаар сарын 2 дах долоо хоногт хийхээр байна.	2024.10.04 утсаар мэдээлэл өгсөн
26	Хүсэлт (Иргэн П.Цэдэнддамба 95952588)	2024.10.23	СБД-ийн 11 дүгээр хороо, 100 айлын гүүрний цахилгаан шат нь ажиллахгүй байна. Шатны зөөлөвч нь салчихсан учраас халтиргаа гулгаатай болсон байна. Энэ асуудалд арга хэмжээ авч өгнө үү.	Инженер техникийн хэсэг, хяналтын инженер Ц.Уранбилэг	Манай байгууллага тус гүүрэн гарцын цахилгаан шатны засвар үйлчилгээг хариуцан ажиллаж байна. Цахилгаан шатуудын орчны температур (+50С-+400С)-т ажиллах техникийн нөхцөлтэй байдаг бөгөөд одоо ашиглагдаж байгаа барилга байгууламж нь	2024.11.11 утсаар мэдээлэл өгсөн

					дулаан алдагдлыг тооцоогүй ямар ч халаалт, дулааныг нь анх шийдвэрлээгүй барьсан байгууламж юм. Тийм учраас өвлийн улиралд эвдрэл гэмтэл, гацалт их гарч байна. Цахилгаан шатуудын хонгилд нэмэлтээр халаагуур суурилуулан өвлийн улиралд ажиллуулах бэлтгэлийг хангаад байна. Бидний зүгээс таны санал, хүсэлтийг хүлээн авч цаашид анхаарч ажиллах болно.		
27	Хүсэлт (Иргэн Б.Болор- Эрдэнэ 88106401)	2024.10.30	БГД-ийн 14 дүгээр хороо 15 дугаар байрны 43 тоотын оршин суугч байна. Манай байрны цахилгаан шатыг тендерт явсан компани 3 сарын турш засаж байна. Одоог хүртэл ашиглалтад орохгүй байгаа нь оршин суугчдад үнэхээр хүндрэлтэй байна. Уг асуудлыг холбогдох байгууллагад нь уламжлан арга хэмжээ аван шалгаж яаралтай ашиглалтад оруулж өгнө үү	Инженер техникийн хэсэг, хяналтын инженер Ц.Уранбилэг	2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр улсын комисс хүлээн авч, ашиглалтад оруулсан.	2024.11.01 утсаар мэдээлэл өгсөн	
28	Гомдол (Иргэн Л.Энх- Амгалан 89088840)	2024.11.12	ХУД-ийн 15 дугаар хорооны 120 мянгатын гүүрэн гарцын цахилгаан шат удаа дараа эвдэрдэг. Өндөр настай хүмүүс зам хөндлөн явах боломжгүй байна. Энэ асуудлыг шийдэж өгнө үү.	Инженер техникийн хэсэг, хяналтын инженер Ц.Уранбилэг	Лифтний ажиллах орчны температур нь (+5-+40) градус байдаг бөгөөд гадаа хүйтэрч байгаагаар холбоотойгоор лифтийн эд ангид хөлдөлт, царцалт үүсэж зарим едөр өглөө эрт асахгүй байгаа болно. Иймд бидний зүгээс лифтийн хонгилд нэмэлт халаагуур суурилуулан аль болох гацалт үүсгэхгүй явуулах тал дээр холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Бусад үед лифт хэвийн ажиллаж байна.	2024.11.15 утсаар мэдээлэл өгсөн	
29	Гомдол (Иргэн Г.Энхтөр 94109955)	2024.11.13	Улаанбаатар лифт нийслэлийн өмчит газар гомдол гаргасаар байна. ХУД-ийн 19-р хороо 54д байрны лифт нь 2,3 жилийн өмнөөс лифт	Инженер техникийн хэсэг,	Лифт угсралтын ажил бүрэн дууссан бөгөөд улсын комисст хүлээлгэн өгөхөөр хүлээгдэж	2024.11.15 утсаар	

30	Гомдол (Иргэн О.Билгүүн 800666066)	2024.11.15	<p>ажиллагаагүй болоод улсаас засахаар болоод 8 сард сэлбэг нь ирсэн. 2 сар засаад одоог болтол дуусаагүй байна. Уг асуудлыг яаралтай шийдвэрлэж засварын ажлыг дуусгаж өгнө үү.</p> <p>БЗД-ийн 18 дугаар хороо 14 дүгээр байрны оршин суугч байна. Манай байрны болон 22а байрны цахилгаан шат хийгдэж дууссан хэвийн ажиллагаатай байгаа ч улсын комисс хүлээн авахгүй байна гэх шалтгаанаар ажиллагаанд оруулахгүй байна. Цахилгаан шатыг хийж гүйцэтгэсэн компаниас бидэнд мэдэгдэхдээ нийт 12 цахилгаан шат хийх ажилтай байгаа бүгдийг нь хийж дууссаны дараагаас улсын комисс зэрэг шалгалтад орно гээд байна гэж хэллээ. Бусад газар авсан ажлыг нь хэзээ хийж дуусна гэж бэлэн болсон цахилгаан шатаа ашиглалтад орохыг хүлээх юм бэ?. Бэлэн болсон зүйлээ шалгаад авмаар байна, оршин суугчид тэвчээртэй 2 сар хүлээлээ шүү дээ. Гомдолтой байна.</p>	<p>хяналтын инженер Ц.Уранбилэг</p>	<p>байна. Улсын комисст хүлээлгэн өгөх албан хүсэлтийг Хяналт Шалгалтын газарт 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр хүргүүлсэн.</p>	<p>мэдээлэл өгсөн</p>
			<p>Инженер техникийн хэсэг, хяналтын инженер Ц.Уранбилэг</p>	<p>Баянзүрх дүүрэгт шинэчлэгдэж буй 12 цахилгаан шатны угсралтын ажлыг "Оакс экспресс монголиа" ХХК бүрэн гүйцэтгэж дууссан бөгөөд улсын комисст хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.</p>	<p>2024.11.21 утсаар мэдээлэл өгсөн</p>	

ТАЙЛАН МЭДЭЭГ ГАРГАСАН:
АРХИВ, БИЧИГ ХЭРЭГ, ДОТООД
АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Н.шил.

Э.НОМИН-ЭРДЭНЭ